



Бүгд Найрамдах Монгол Ард Улсын  
Сайд нарын Зөвлөлийн  
ТОГТООЛ

1971 оны 2 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 46

Улаанбаатар  
хот

Орон тоо бий болгохыг  
зөвшөөрөх тухай

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Хөнгөн ба хүнсний үйлдвэрийн бүтээгдэхүүний этикетик, зүүлт, цаасан боодлын зураг, чимэглэлийн эх загварыг гарган, хэвлүүлж, харьяа үйлдвэрүүдээ хангам байх үүрэг бүхий хоёр хүнийг яамныхаа бүтээгдэхүүний чанар, стандартын хэлтэст авч ажилдуулахыг Хөнгөн ба хүнсний үйлдвэрийн яам /н. ДАМДИН/-д зөвшөөрсүгэй.

2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын тусламж, Эдийн засгийн харилцан туслалх зөвлөл, гадаад харилцааны асуудал хариуцсан мэргэжилтэн нэгийн орон тоо бий болгохыг Ойн аж ахуй, мод боловсруулах үйлдвэрийг удирдах ерөнхий газар /н. ЧИМИДЦЭРЭН/-т зөвшөөрсүгэй.

3. Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаа, 4 районы гүйцэтгэх захиргаадад зохион зааварлах хэлтсийн даргын орон тоо тус бүр нэгийг батлагдсан орон тоондоо багтаан бий болгохыг Улаанбаатар хотын гүйцэтгэх захиргаа /н. ЦЭРЭН/-д зөвшөөрсүгэй.

БНМАУ -ын Сайд нарын  
Зөвлөлийн орлогч дарга

Т. РАГЧАА

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн  
Хэрэг эрхлэх газрын дарга

Б. БАДАРЧ

Хуулбар үнэн: Тогтоол ангийн  
эрхлэгч

/Ш. РИНЧИН/